

Ангилалтын код 67.060

Цагаан будаа. Техникийн шаардлага	MNS ISO 7301:2024
Rice. Specification	ISO 7301:2021 MNS ISO 7301:2000-ын оронд

Стандарт, Хэмжил зүйн газрын даргын 2024 оны сарын-ны өдрийн тоот тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 20 ... оны ... сарын ... өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах болон хэрэглэх хүрээ

Энэ стандарт нь улс хооронд худалдаалагддаг будааны (*Oryza sativa* L.) хамгийн доод шаардлагыг тогтоосон болно. Боловсруулсан ба боловсруулаагүй будааны үр (үнэртэй болон үнэртэй бус), боловсруулсан ба боловсруулаагүй, хүнсний хэрэглээнд зориулсан будааны төрөлүүд багтана. Будаанаас гаралтай бусад бүтээгдэхүүнд (ж: цавуулаг будаа) хамаарал үгүй болно.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах стандартын үзүүлэлт, шаардлагаас иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн шинэчилсэн эх материалыг ашиглана. Үүнд:

ISO 712, *Амуу тариа, тариан гаралтай бүтээгдэхүүнүүд — Чийглэгийн хэмжээг тодорхойлох — Лавлагааны арга*

ISO 11746, *Будаа — Үрний биометрик онцлог тодорхойлолт*

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэ стандартад дараах нөхцөл, тодорхойлолт, нэршилүүд хэрэглэгдэнэ.

ISO болон IEC нь дараах хаягуудад нэр томёоны стандартын дата санг хадгалсан болно:

- ISO Интернет орчин дахь платформ: <https://www.iso.org/obp>
- IEC Электрон сан: <http://www.electropedia.org/>

3.1**түүхий тутарга**

тутарга

боловсруулаагүй будаа

Хураасны дараа хальстай будаа

3.2**хальсалсан будаа**

бор будааны үр

карго будааны үр

түүхий тутарга (3.1) зөвхөн хальс хуулсан хэсэг будаа

ТАЙЛБАР: Хальслах явцад будааны үрны жин багасаж болно.

3.3

өнгөлсөн будаа

цагаан будааны үр

механик тээрэм ашиглан хальсалсан будааны (3.2) үрнээс хивэгийг ялгасан будаа

3.3.1

дутуу тээрэмдсэн будаа

хивэг болон үр хөврөлийн зарим хэсгийн салгах аргаар хальсалж (3.2) гаргасан будаа

3.3.2

сайн тээрэмдсэн будаа

хальсалж тээрэмдэх замаар олж авсан будаа (3.2) ихэнх хивэг болон үр хөврөлийн хэсгийг арилгасан

3.3.3

нэмэлт сайн тээрэмдсэн будаа

хальсалж тээрэмдэж гаргаж авсан будаа (3.2) бүх хивэг болон бүх үр хөврөлийн устгах замаар гаргаж авсан будаа

ТАЙЛБАР 1. Үр хөврөлийн ул мөр агуулсан цөмийн хамгийн их агууламж 0.5% -иас бага хэмжээтэй, туршилтын хэсэг 100 гр бага байх ёстой (А.4.3.3 ийг үзнэ үү)

3.4

боловсруулсан будаа

гидротермал процессоор цардуулагдаж желатинжлагдан хатаагдсан будаа

3.5

боловсруулсан өнгөлсөн будаа

Хальслагдсан будааны үрийг гидротермал процессд оруулж желатинжлан хатаасан будаа

3.6

боловсруулсан хальсалсан будаа

хальслагдсан будааны үрийг гидротермал процессд оруулж желатинжлан хатаасан будаа

3.7

цавуулаг будаа

наалдамхай будааны үр

Цагаан, тунгалаг өнгийн будааны үрны төрөл

ТАЙЛБАР: Бага хэмжээний амилоз агууламтай ба амилопектинаас бүрддэг. Чанагдсаны дараа хоорондоо наалдах чанартай

3.8

үнэртэй будаа

чанагдах явцад ямар нэгэн үнэр ялгаруулдаг будааны үр (Ж:самар, эрдэнэ шиш)


3.9

бүхэл будааны үр
эврэлгүй будааг хэлнэ

3.10

бүтэн будааны үр
хальсалсны дараа бүхэл биеийн дундаж уртаас 90% -аас дээш хэмжээтэй.

ТАЙЛБАР 3: Зураг 1.



Түлхүүр үг

- | | | | |
|---|--|-----------|---|
| 1 | Бүтэн будааны үр (3.10) | 5 | Толгой будааны үр (3.11) |
| 2 | Их эвдрэлтэй будааны үр (3.13) | 6 | Цуурсан будааны үр (3.12) |
| 3 | Дунд эвдрэлтэй будааны үр (3.14) | 7 | Хагарал (3.16) |
| 4 | Бага эвдрэлтэй будааны үр (3.15) | \bar{L} | Дундаж урт (3.17) |

1-р зураг-Будааны үрны хэмээ, эвдрэл ба цуурал

3.11

түрүү будаа
бүтэн үрийн $\frac{3}{4}$ хэмжээтэй будааны үр

3.12

эвдрэлтэй үр

бүтэн үрийн $\frac{3}{4}$ хэмжээнээс бага хэмжээтэй будааны үр болох ба 1.4мм хэмжээтэй шигшүүрээр нэвтрэхгүй болно.

3.13

их эвдрэлтэй үр

бүтэн үрийн $\frac{3}{4}$ хэмжээнээс бага ба $\frac{1}{2}$ -ээс том будааны үрны үр

3.14

дунд эвдрэлтэй үр

бүтэн үрийн $\frac{3}{4}$ хэмжээнээс том ба $\frac{1}{2}$ -ээс бага будааны үр

3.15

бага эвдрэлтэй үр

бүтэн үрийн $\frac{3}{4}$ хэмжээнээс бага боловч 1.4мм хэмжээтэй шигшүүрээр багтахгүй будааны үр

3.16

эмтэрхий

1.4мм шүүлтүүрээр нэвтэрсэн будааны үр

3.17

дундаж урт (L)

тестийн дээжүүд болох будааны үрны Бүтэн үрийн математик дундажлал

3.18

бусад хольц

хальсалсан ба хальслаагүй будааны үрны хальснаас гаднах органик ба органик бус хоргүй бусад хольц

3.19

органик бус бусад хольц

чулуулаг, шороон ширхэгс, элс

3.20

органик бусад хольц

Идэх боломтой ба идэх боломжгүй хольц

3.21

идэх боломжтой хольц

шигшдэс, бусад үрийн төрөл

3.22

идэх боломжгүй хольц

хальс, хивэг, бусад зүйл

3.23

халууны гаралтай гэмтсэн үр

өнгө хувирсан будааны үр

ТАЙЛБАР: Энэ ангилал нь боловсруулаагүй будааны үрны тохиолдолд шар ба хар шар өнгөтэй, боловсруулсан будааны үрны тохиолдолд улбар шар ба хар улбар шар өнгөтэй будааны үр оруулдаг

3.24

эвдрэлтэй үр

харах байдлаас халууны гаралтай бус чийгшил, шавьж, өвчин эсвэл бусад шалтгаануудаас болж чанарын муудалт үзүүлж буй будааны үр

3.25

гүйцэд боловсроогүй ба хэлбэргүй үр

Гүйцэд боловсроогүй ба хэлбэргүй будааны үр

3.26

гуриланцар үр

Боловсруулаагүй будааны үр (цавуулаг бус) саарал болон гуриллаг будааны үр

3.27

улаан үр

Будааны үрны Бүтэн үрийн $\frac{1}{4}$ -ээс илүү хэсэг нь улаан өнгөтэй байна

3.28

улаан судалт үр

Будааны үрны бүх биеийн талаас том судалтай ба биений гадаргуун $\frac{1}{4}$ -ээс илүүгүй хэсэг нь улаан судалаар бүрхэгдсэн байна

3.29

хэсэг желатинжлагдсан будааны үр

Хальстай, Өнгөлсөн бүрэн бус желатинжлагдсан будааны үр

3.30

пек

Бүтэн үрийн биений $\frac{1}{4}$ -ээс илүү хэсэг нь хар бор, хар өнгөтэй будааны үр

3.31

стрессээс үүдэлтэй хагарсан будааны үр

Будааны үрны Бүтэн үрийн $\frac{3}{4}$ -ээс илүү зай нь хагаралттай байна

4

Техникийн ерөнхий шаардлага

4.1 Эрүүл мэнд, мэдрэхүйн эрхтний болон ерөнхий шинж чанар

Өнгөлсөн, хальсалсан, хальслаагүй, боловсруулсан, боловсруулаагүй, хагаралтай, хагаралгүй үр нь гадны ямар нэг үнэргүй, цэвэр, сайн чанартай байна. Ямар нэгэн хорт хольцгүй байна.

Пестицидийн үлдэгдэл болон бусад бохирдол нь ХХААБ/ДЭМБ Хүнсний Эрх Зүйн Комиссоос зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхүй байна.

Нүдэнд харагдахуйц амид биет, хортон шавьж байж болохгүй.

4.2 Хими, физик шинж чанар

Бүтээгдэхүүний чийглэл 15.0% - ээс ихгүй байх.

ТАЙЛБАР Хадгалалт, тээвэрлэлтийн үед цаг уурын нөхцлөөс хамаарч дээрх үзүүлэлтээс бага хэмжээний чийглэлтэй байж болно. ISO 6322-1^[2], ISO 6322-2^[3] and ISO 6322-3^[4].

Физик шинж чанар нь А хавсралтанд заасан аргын дагуу тогтоох бөгөөд 1-р хүснэгтэнд үзүүлсэн үзүүлэлтээс хэтрэхгүй байна.

DRAFT

1-р хүснэгт — физик шинж чанарын тодорхойлолт

Шинж чанар	Боловсуураагүй		Боловсруулсан	
	Хальсалсан будаа %	Өнгөлсөн будаа %	Хальсалсан будаа %	Өнгөлсөн будаа %
Органик бус гадны хольц	0,5	0,5	0,5	0,5
Органик гадны хольц	1,0	0,5	1,0	0,5
Идэж болох гадны хольц	1,0	0,5	1,0	0,5
Идэж болохгүй гадна хольц	0,5	0,5	0,5	0,5
Тутарга	2,5	0,3	2,5	0,3
Боловсруулаагүй хальсалсан будаа	—	1,0	1,0	1,0
Боловсруулаагүй будаа	1,0	—	1,0	1,0
Боловсруулсан хальсалсан будаа	1,0	1,0	—	1,0
Боловсруулсан будаа	1,0	1,0	1,0	—
Эмтэрхий	0,1	0,1	0,1	0,1
Түлхүүр үгс				
— Хамааралгүй				
а Боловсруулсан				
b Бүтэн улаан (карго) будааг оруулаагүй болно				
c Хагаралтай будааны хувь нь будааны ашиглалтын зорилгоос хамаараад худалдагч ба худалдан авагч хооронд тохиролцоно. Стрессээс хагарсан будааны тодорхойлолт С хавсралтыг дагана				

1-р хүснэгт үргэлжлэл

Шинж чанар	Боловсуураагүй		Боловсруулсан	
	Хальсалсан будаа %	Өнгөлсөн будаа %	Хальсалсан будаа %	Өнгөлсөн будаа %
Халууны гаралтай гэмтсэн үр	2,0 ^a	2,0	2,0 ^a	2,0
Эвдрэлтэй үр	4,0	3,0	4,0	3,0
Гүйцэд боловсроогүй ба хэлбэргүй үр	8,0	2,0	8,0	2,0
Гуриланцар үр	5,0 ^a	5,0	—	—
Улаан үр	12,0 ^b	12,0	12,0 ^b	12,0
Желатинжлагдсан үр	—	—	11,0 ^a	11,0
Пек	—	—	4,0	2,0
Цавуулаг будаа	1,0 ^a	1,0	1,0 ^a	1,0
стрессээс үүдэлтэй хагарсан будааны үр	— ^c	—	—	—
Түлхүүр — Хамааралгүй a Боловсруулсан b Бүтэн улаан (карго) будааг оруулаагүй болно c Хагаралтай будааны хувь нь будааны ашиглалтын зорилгоос хамаараад худалдагч ба худалдан авагч хооронд тохиролцоно. Стрессээс хагарсан будааны тодорхойлолт С хавсралтыг дагана				

4.3 Тохирлцооны хамгийн бага үзүүлэлтийн заалт

Худалдан авагч ба худалдагч талуудын тохирлцоонд байх ёстой теникийн заалтын хамгийн бага үзүүлэлт:

a) Эвдрэлтэй үрний зөвшөөрөгдөх дээд хэмжээ (%).

b) Зөвшөөрөгдөх дээд хэмжээ 1-р хүснэгтээс илүүгүй байна.

Тодорхой төрлийн будаа эсвэл тодорхой сортын будааны хувьд багцын төрлийн байдлыг үнэлэхийн тулд гэрээнд бүх цөмийн дундаж урт болон түүнтэй холбоотой өөрчлөлтийн коэффициент, Cv , %, -ийг дараах томёогоор тогтооно.

$$Cv = \frac{S}{\bar{L}} \times 100$$

S - Дундаж хэлбэлзэл;

\bar{L} - Дундаж өндөр.

с) тээрэмдэх зэрэг, тухайлбал дутуу тээрэмдсэн будаа, сайн тээрэмдсэн будаа, эсвэл хэт сайн тээрэмдсэн будаа зэрэг хүлцлийг тодорхойлж массыг %-иар илэрхийлнэ.

5 Шинжилгээний дээж авах

Чийгशीлийн хэмжээ ISO 712 –ийн дагуу байна.

Биометрикийн заалт ISO 11746 –ийн дагуу байна.

Бусад шинжилгээнүүд нь А, Б хавсралтын дагуу байна.

6 Сав баглаа боодол

Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг гэмтээх гадны ямар нэг бодис агуулаагүй, гадны үнэр, амтыг нэвтрүүлэхгүй байвал зохино.

Хэрэв шуудайнд савласан бол уг шуудай нь бат бөх, цэвэр байвал зохино.

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

Будааны төрөл, шинж тэмдгийг ялгах, анализийн арга

А.1 Зарчим

1-р хүснэгт-д заасан ангиллын эвдрэлтэй үр, толгой үрийг гараар ялгаж жинлэнэ.

А.2 Тоног төхөөрөмж

А.2.1 Дээж хуваагч конус хэлбэрийн ба түгээх систем бүхий олон тооны нүхтэй дээж авагч.

ЖИШЭЭ ISO 24333-д заасан дээж авагч

А.2.2 Шигшүүр, ISO 5223-д заасан 1.4мм-ийн диаметр бүхий нүхтэй байна.

А.2.3 Хямсаа.

А.2.4 Шинжилгээний аяга.

А.2.5 Жин 0,01грам-ын нарийвлалтай байна

А.2.6 Тавиур эсвэл бусад хэрэгсэл, шинжилгээ хийх гэж буй будаанаас тэс өнгөтэй байна.

А.2.7 Хэмжих хэрэгсэл, үрэнд гэмтээл өгөхгүй ба 0.1мм –ийн нарийвчлалтай байна.

А.3 Шинжилгээний дээж авах

Шинжилгээний дээж авахыг энэхүү стандартад тусдаа заалт тавиагүй бөгөөд ISO 24333 –с харахийг санал болгож байна.

А.4 Процедур

А.4.1 Ерөнхий

Ямар нэгэн эвгүй үнэр илэрсэн, түүнчлэн ямар нэгэн гажиг илэрсэн бол харааны үзлэгээр амьд болон үхсэн шавж байгаа эсэхийг шалгаж, тоог нь мэдээлнэ үү.

А.4.2 Шинжилгээний дээж бэлдэх

Дээжийг сайтар хольж нэгэн жигд болгоод энэ стандартын А2.1-д заасан дээж хуваагчийг хэрэглэн 800г дээж авна.

Авсан дээжээ 2 шинжилгээний ижил 400г хуваана.

А.4.3 Зорилт

А.4.3.1 Ерөнхий

Будааны үр эсвэл будааны үрны хэсэг Таблиц 1-д заасанаар хэд хэдэн ангилалд хамаарч болох ба хамгийн бага зөвшөөрөгдөх дээд утгатай ангилалд ангилагдах ёстой. Шалгалтын шигшүүрийн нүхэнд хавчуулагдан үлдсэн будааны үр нь шигшүүрт үлдсэн гэж тооцно.

А.4.3.2 Боловсруулаагүй хальсалсан будаа

Шинжлэх дээжийг нийт 2 хуваах ба шинжлэх дээжийн нэг бүлгийг 0,01г-ийн нарийвчлалтай (А.4.2-ийн дагуу) жинлэж, массыг m_w -р тэмдэглэн тавиур (А.2.6) дээр дэлгэн тавина. Хямсаа, мэс заслын хутга, будгийн багс(А.2.3) ашиглан органик бус, гадны органик хольц, түүхий тутарга, боловсруулаагүй өнгөлсөн будаа, боловсруулсан хальсалсан будаа, боловсруулсан өнгөлсөн, хальсалсан будааг шинжилгээний аяганд (А.2.4) ялгана. 6-н төрлийн дээжийг ойролцоогоор 0,01г нарийвчлалтай жинлэн массыг $m_1, m_2, m_3, m_4, m_5, m_6, m_7, m_8$ -р тэмдэглэнэ.


2 дахь шинжилгээний дээжийг дээж хуваагч (А.2.1) ашиглан 100г хэмжээтэй ижил тэнцүү 4 хэсэг ялгана.

Эхний хэсэгийг 0,01г нарийвчлалтайгаар массыг жинлэж m_w –р тэмдэглэнэ. Эвдрэлтэй болон дутуу, гүйцэд боловсроогүй, хэлбэргүй үр, улаан үрийг шинжилгээний аяганд (А.2.4) ялгана. Ялгасан 3н төрлийн массыг тус тусд нь m_9, m_{10}, m_{11} гэж тэмдэглэнэ.

Эмтэрхийг шинжилгээний шүүлтүүр (А.2.2) -ийн тусламжтайгаар салгаж, үлдсэн хэсгийг дэлгэн тавин эвдрэлтэй үрийг их эвдрэлтэй үр, дунд эвдрэлтэй үр, бага эвдрэлтэй үр гэж ангилан шинжилгээний аяганд ялгана. Ялгасан дөрөв хэсгийг 0,01 г-ийн нарийвчлалтай жинлэж, массыг $m_{12}, m_{13}, m_{14}, m_{15}$ -р тэмдэглэнэ.

Гурав дахь хэсэгт лабораторийн өнгөлгөө хийнэ. Өнгөлсөн будааг 0,01г-ийн нарийвчлалтай жинлэн m_z -р тэмдэглэнэ. Тавиур дээр дэлгэн тавьж халууны гэмтэлд өрстсөн үр, гуриланцар үр, цавуулаг будааг шинжилгээний аяганд ялгаж массыг m_{16}, m_{17}, m_{18} -р тэмдэглэнэ.

Зураг А.1 –с иш татна уу.



Зураг А.1 — Боловсруулаагүй хальсалсан будааны схем

A.4.3.3 Боловсруулаагүй өнгөлсөн будаа

Шинжлэх дээжийг нийт 2 хуваах ба шинжлэх дээжийн нэг бүлгийг 0,01г-ийн нарийвчлалтай (A.4.2-ийн дагуу) жинлэж, массыг m_W -р тэмдэглэн тавиур (A.2.6) дээр дэлгэн тавина.

Хямсаа, мэс заслын хутга, будгийн багс (A.2.3) ашиглан, органик бус бусад хольц, органик бусад хольц, түүхий тутарга, боловсруулаагүй хальсалсан будаа, боловсруулсан хальсалсан будаа, боловсруулсан өнгөлсөн будааг шинжилгээний аяганд (A.2.4) ялгана. 6-н төрлийн дээжийг ойролцоогоор 0,01г нарийвчлалтай жинлэн массыг $m_1, m_2, m_3, m_4, m_5, m_6, m_7, m_8$ -р тэмдэглэнэ.

2 дахь шинжилгээний дээж бүлгийг дээж хуваагч (A.2.1) ашиглан 100 г хэмжээтэй ижил тэнцүү 4 хэсэг ялгана.

Эхний хэсэгийг 0,01г нарийвчлалтайгаар массыг жинлэж m_W –р тэмдэглэнэ. Халууны гаралтай гэмтсэн үр, эвдрэлтэй үр, гүйцэд боловсроогүй ба хэлбэргүй үр, гуриланцар үр, улаан үр, улаан судалт үр болон цавуулаг будааг шинжилгээний аяганд (A.2.4) ялгана. Ялгасан үр, будааны массыг тус тусд нь $m_9, m_{10}, m_{11}, m_{12}, m_{13}, m_{14}$ гэж тэмдэглэнэ.

Хоёр дахь хэсэгийг жинлэж m_U –р тэмдэглэнэ. Эмтэрхийг шинжилгээний шүүлтүүр (A.2.2) -ийн тусламжтайгаар салгаж, үлдсэн хэсгийг дэлгэн тавин эвдрэлтэй үрийг их эвдрэлтэй үр, дунд эвдрэлтэй үр, бага эвдрэлтэй үр гэж ангилан шинжилгээний аяганд ялгана. Ялгасан дөрөв хэсгийг 0,01 г-ийн нарийвчлалтай жинлэж, массыг m_{16}, m_{17}, m_{18} -р тэмдэглэнэ

А.4.3.4 Боловсруулсан хальсалсан будаа

Шинжлэх дээжийг нийт 2 хуваах ба шинжлэх дээжийн нэг бүлгийг 0,01г-ийн нарийвчлалтай жинлэж, массыг m_W -р тэмдэглэн тавиур (А.2.6) дээр дэлгэн тавина. Хямсаа, мэс заслын хутга, будгийн багс (А.2.3) ашиглан, органик бус бусад хольц, органик бусад хольц, түүхий тутарга, боловсруулаагүй хальсалсан будаа, боловсруулаагүй өнгөлсөн будаа, боловсруулсан өнгөлсөн будааг шинжилгээний аяганд (А.2.4) ялгана. 6-н төрлийн дээжийг ойролцоогоор 0,01г нарийвчлалтай жинлэн массыг $m_1, m_2, m_3, m_4, m_5, m_6, m_7, m_8$ -р тэмдэглэнэ.

2 дахь шинжилгээний дээж бүлгийг дээж хуваагч (А.2.1) ашиглан 100 г хэмжээтэй ижил тэнцүү 4 хэсэг ялгана.

Эхний хэсэгийг 0,01г нарийвчлалтайгаар массыг жинлэж m_x -р тэмдэглэнэ. Тавиур дээр дэлгэн тавиж, гэмтсэн үр, хэлбэргүй эсвэл буруу хэлбэртэй үр, улаан үрийг шинжилгээний аяганд ялгана. Үүссэн гурван хэсгийг ойролцоогоор 0,01 г-ийн нарийвчлалтай жинлэж, массыг m_9, m_{10}, m_{11} -р тэмдэглэнэ.

Хоёр дахь хэсэгийг 0,01г нарийвчлалтайгаар массыг жинлэж m_y –р тэмдэглэнэ. Эмтэрхийг шинжилгээний шүүлтүүр (А.2.2) -ийн тусламжтайгаар салгаж, үлдсэн хэсгийг дэлгэн тавин их, дунд, бага эвдрэлтэй үрийг ангилан шинжилгээний аяганд ялгана. Ялгасан дөрөв хэсгийг 0,01 г-ийн нарийвчлалтай жинлэж, массыг $m_{12}, m_{13}, m_{14}, m_{15}$ -р тэмдэглэнэ.

Гурав дахь хэсэгт лабораторын өнгөлгөө хийнэ. Өнгөлсөн будааг 0,01г нарийвчлалтай жинлэн массыг m_z –р тэмдэглэнэ. Халууны гаралтэй гэмтэлтэй үр, желатинжлагдсан үр, пек –г шинжилгээний аяганд ялгана. 0,01г –ийн нарийвчлалтай жинлэж m_{16}, m_{17}, m_{18} –р тэмдэглэнэ.

Дөрөв дахь хэсэгт өнгөлгөө хийж В хавсралтын дагуу цавуулаг будааны хэмжээг тогтооно.

В хавсралт

(норматив)

Боловсруулсан будааны цавуулагын хэмжээг тогтоох

В.1 Зарчим

Цавуулагтай будаа нь иодины уусмалд улаавтар бор өнгөтэй байх ба цавуулаг бус будааны үр цэнхэр өнгөтэй байна.

В.2 Бодис ба материалууд

Шинжилгээний үед шинжилгээний зориулалтын ба шинжилгээний хэмжээнд ариутгагдсан бодис ба ус ашиглана.

В.2.1 **Иодны эх бодис**, 100мл усанд 0,2 г иод ба 2,0 г потассиумны иод уусмал.

В.2.2 **Иодны ажлын бодис**, иодны эх бодисыг 2 дахин их усанд уусгаж бэлдэх

В.2.3 Цаас.

В.3 Тоног төхөөрөмж

В.3.1 **Хэмжигч, 0,01 г-н нарийвчлалтай.**

В.3.2 **Шил**, 250 мл хэмжээтэй.

В.3.3 **Жижиг цагаан өнгийн аяга.**

В.3.4 Утсан сав.

В.3.5 Хутгагч.

В.3.6 Хямсаа.

В.4 Дээж бавах

Дээж авах тухай энэ стандартанд мэдээллэхгүй бөгөөд ISO 24333^[5]-с харна уу.

В.5 Тодорхойлолт

В.5.1 100г будаа ялган авч лабораторын шилэнд хийнэ.

В.5.2 80мл иодны уусмал ([В.2.2](#)) хийж 30 секунд ажина.

В.5.3 Утсан саванд ([В.3.4](#)) цутган будааны үрийг шүүнэ. Үрийг цаас ([В.2.3](#)) –д ороон илүүдэл шингэнг хатаана.

В.5.4 Үрийг цагаан аяга ([В.3.3](#))-д хийж хар хөх туяатай энгийн будаа, улаан бор туяатай цавуулаг будааг ялгана.

В.5.5 Цавуулаг будааг ялгаж жинлэж, m_{19} -р тэмдэглэнэ. Цавуулаг бус будааг m_{20} -р тэмдэглэнэ.

В.5.6 Цавуулагын хэмжээ, w -г дараах томёоны дагуу бодно:

$$W = \frac{m_{19}}{m_{19}+m_{20}} \times 100$$

(В.1)

С хавсралт

(норматив)

Боловсруулаагүй будааны стресс гаралтай эвдрэл, хагаралттай будааны хэмжээг тогтоох

С.1 Зарчим

Стресс-с гаралтай үрний эвдрэл зөвхөн ретро гэрэлтүүлгийн өнгөлөлтөөр өнгөлсөн будааны үрийн томруулагч аар илрүүлнэ.

С.2 Тоног төхөөрөмж

С.2.1 Цэвэр ретро гэрэлтүүлгийн тавцан.

С.2.2 Томруулагч (2:1 хамгийн бага томруулагчын хэмжээ).

С.2.3 Хямсаа.

С.3 Дээж авах

Дээж авах тухай энэ стандартанд мэдээллэхгүй бөгөөд ISO 24333^[5]-с харна уу.

С.4 Тодорхойлолт

С.4.1 Өнгөлсөн 100ш будааг санамсаргүй сонголтоор шилнэ.

С.4.2 Гэрэлтүүлгийн тавцан дээр эхний сэтийг тараана. Томруулагчаар хагаралын хэмжээг тогтооно.

С.4.3 2 дахь сэтийг адил аргаар шалгана.

С.4.4 Дараах томёогоор эвдрэл, хагарлын хэмжээг тогтооно:

$$C = \frac{(x_1 + x_2)}{2}$$

